

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ХЭРЭГЖИЛТ
МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ САЙН ДУРЫН ХОЁРДУГААР ИЛТГЭЛИЙН
ҮНДСЭН САНАА

Нэг. Оршил

Монгол Улс Үндэсний сайн дурын илтгэлээ анх 2019 онд танилцуулсан бөгөөд хоёр дахь удаагийн илтгэлээ ийнхүү танилцуулж байна.

Энэ удаагийн илтгэлд Тогтвортой хөгжлийн зорилгын Монгол Улс дахь хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт бүрээр үнэлж, үндэсний түвшинд авч хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, хүч чармайлтыг танилцуулж буйн зэрэгцээ анхны илтгэлээс гарсан зөвлөмжийн хэрэгжилтийн үр дүнг тусгав. Ийнхүү үнэлэхдээ дэлхий нийтэд тархсан КОВИД-19 цар тахал, геополитикийн зөрчилдөөний үр нөлөөг авч үзэн, хөгжлөөс орхигдсон бүлгийг онцолж, тогтвортой хөгжилд бүс, орон нутгийн хөгжлийн ялгаатай байдал хэрхэн нөлөөлж буйг тодорхойлохыг зорив.

Хоёр. Тогтвортой хөгжлийн зорилгын ахиц дэвшил

Эхний илтгэлийн зөвлөмжийн дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн батлах, нэгдсэн бодлого, төлөвлөлтийн институцыг бий болгох зэргээр үндэсний түвшинд бодлого, төлөвлөлт, эрх зүйн орчныг сайжруулсан. Улмаар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг Тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн төлөөх түншлэл өргөжиж, төр, хувийн хэвшлийн санаачилга, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо идэвхжин, олон талт хамтын ажиллагаа улам бэхэжсээр байна.

Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг үндэсний онцлогт нийцүүлэн 16 зорилго, 134 зорилттойгоор томьёолж, түүний хэрэгжилтийг хэмжих дэлхийн 156, үндэсний 35, нийт 191 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсноор хэрэгжилтийг үнэлэх арга хэрэгсэл илүү сайжирсан бөгөөд анхны илтгэлтэй харьцуулахад өгөгдлөөр баримтжуулсан дүгнэлтүүдийг чухалчлав.

Монгол Улсын хувьд 15 зорилгын хэрэгжилт тодорхой түвшинд ахицтай, нэг зорилго болох ядуурлыг бууруулах зорилгын хэрэгжилт бууралттай үнэлэгдлээ.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал, геополитикийн зөрчилдөөн зэрэг нь Монгол Улсын эдийн засаг, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэв. Тухайлбал, цар тахлаас өмнө нэг ажилчинд ногдох бодит дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэж, эдийн засгийн бодит гүйцэтгэл сайжирч байсан боловч 2020 онд эдийн засаг 4.6 хувиар агшсан. Харин

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн эдийн засгаа богино хугацаанд сэргээх бодлогын арга хэмжээний дүнд 2022 онд эдийн засаг 4.8 хувиар өслөө.

Нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн бэлэн байдал хангалтгүй байсан хэдий ч хариу арга хэмжээг хурдан шуурхай авч хэрэгжүүлсний үр дүнд цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулж чадсан. Гэвч эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, түргэн шуурхай хүргэх нөөц, хангамж дутагдалтай байсан нь эрүүл мэндийн бусад үйлчилгээний хүртээмжид нөлөөлсөн байна.

Сүүлийн жилүүдэд боловсролын хүртээмж нэмэгдэж, сургалтын шинэлэг арга хэрэгслийг нэвтрүүлснээр цар тахлын үед цахим сургалтын орчин илүү сайжирлаа. Гэвч боловсролын тэгш бус байдал нэмэгдсэн байна.

Нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжил, хүн амын боловсрол, өрхийн амьжиргааны түвшний ялгаатай байдал нь хөгжлөөс хоцрогдох шалтгаан болж байна. Ялангуяа, нийслэлээс алслагдсан хүн амын нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж бага буюу цаашид хөгжлөөс хоцрогдох хамгийн өндөр эрсдэлтэй байна.

Гадаргын усны нөөц, урсац бүрэлдэх эхийг хамгаалах, ойн санг нэмэгдүүлэх, ургамал, амьтны нөөцийг хамгаалах чиглэлд ахиц гарч буй боловч уламжлалт хөдөө аж ахуй, эрчим хүчний салбарын үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал буураагүй байна. Тухайлбал, нийт эрчим хүчний эцсийн хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь дорвитой өсөөгүй байна.

Гурав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Тогтвортой хөгжлийн зорилгын 2030 оны зорилтод хүрэх, цаашдын хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд,

1. Дунд, богино хугацааны бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг хангахдаа хяналт, тайлагналын тогтолцоог сайжруулж, үнэлгээг чанаржуулах,

2. Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх санхүүжилт, хөрөнгө оруулалтын орчныг тодорхой болгож, олон талын оролцоог идэвхжүүлэх арга хэрэгсэл болгон ашиглах,

3. Дэлхий нийтийг хамарсан зөрчил, мөргөлдөөн, халдварт өвчин, байгалийн гамшигт үзэгдэл, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөг бууруулах, эрсдэлийг даван туулах, өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн олон улсын түншлэл, бүс, орон нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, нөөцийн эх үүсвэрийн бэлэн байдлыг хангах зэргээр нийгэм, эдийн засгийн суурь чадавхыг бэхжүүлэх,

4. Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмын хүрээнд бүс, орон нутгийн хөгжлийн ялгаатай байдлыг бууруулах, уул уурхайн болон уул уурхайн бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн тээврийн дэд бүтэц, логистикийн сүлжээг бий болгох, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмжийг бүх хүн амд тэгш хүртээх зэрэгт хүчин чармайлт гаргаснаар тогтвортой хөгжлийн суурь зарчмыг хангах чухал ач холбогдолтой.

Иймд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн төлөөх хүч чармайлт, оролцоог дэмжиж, хамтын ажиллагааг өргөжүүлэн, түншлэлийг бэхжүүлэхийг уриалж байна.